Увс аймгийн ИТХ, Тэргүүлэгчдийн 2014 оны ажлын тайлан

Нэг. Зохион байгуулсан ажил ,үйл ажиллагааны үр дүн

- Аймгийн ИТХ-ын энэхүү бүрэн эрхийн хугацааны үйл ажиллагааны чиглэлүүдэд тусгагдсан

бодлогын зорилтуудын хүрээнд аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэн НӨУБайгууллагуудын үйл ажиллагаанд "**Аймаг, сумдын ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхжуулах жил"** болгох зорилт дэвшүүлж энэхүү зорилтоо хангахад үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллав. Үүнд:

- Бүх шатны Хурлын төлөөлөгчид, сумдын ИТХ-ын болон ажлын албаны ажилтан,

мэргэжилтнүүдийг хариуцсан, сонгуульт үүргээ биелүүлэхэд нь сургаж дадлагажуулах, ажлын туршлага- арга барил, бүтээн байгуулалттай танилцуулах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, шаардлагатай лавлагаа мэдээллээр хангах, үйл ажиллагааг нь журамлан зохион байгуулах, оролцоог нь дээшлүүлэх, гаргасан идэвх санаачлагыг нь дэмжин хөгжүүлэх, түүнд шаардлагатай санхүү, техникийн нөхцөл бүрдүүлэх олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлснээр аймгийн ИТХ, түүний зохион байгуулалтын бүх нэгж хэсгүүдийн үйл ажиллагаа тогтворжин төлөвших, сумдын ИТХ-ууд бие дааж санаачлага гаргах, багийн ИНХ-ууд иргэддээ хүрч тодорхой үр дүнтэй ажиллах зэрэг хандлага, өөрчлөлт гарлаа.

Тухайлбал: "Сумын ИТХ-ын даргын манлайлал" сэдвээр Давст суманд нийт сумдын ИТХ-ын дарга нарын туршлага солилцох уулзалт, "Сумын ИТХ-ын ажлын төлөвлөлт, зохион байгуулалт, багийн ИНХ-ын ажлын үр дүн" сэдвээр Ховд сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, Халиунбулаг багийн ИНХ-ын ажилтай танилцах зөвлөлгөөн, " Иргэний оролцоог хангах" асуудлаар Зүүнговь сумын Иргэний танхимын ажил дээр үзүүлэх сургууль тус тус зохион байгуулж түүнд 19 сумын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга, иргэний танхимын ажилтнууд нийт 59 хүнийг оролцуулж харилцан туршлага солилцлоо.

Ховд аймагт АТГ-аас зохион байгуулсан сургалтанд 19 сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн

нарийн бичгийн дарга, Завхан аймагт болсон "Малын хулгайгүй бүс нутаг" зөвлөгөөн, "Нийгмийн түншлэл" зөвлөгөөн, "Залуучуудын ТББ-ын чадавхийг бэхжүүлэх нь" сургалт, аймаг, сумын ИТХ-ын цахим хуудас хөгжүүлэх "НӨУБ-ын чадавхийг бэхжүүлэх нь" төслийн сургалтанд ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэнүүд 10 удаа оролцлоо.

Аймгийн ИТХ-ын болон тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэх асуудал, ялангуяа төсөв, ОНХС-ийн зарцуулалт, хөрөнгө оруулалт, зээл, хөтөлбөр төслүүдэд хамруулах асуудлыг олон нийтийн болон багийн ИНХ-аар хэлэлцүүлэг

зохион байгуулж эрэмблэн шалгаруулж, шийдвэр гаргахад иргэдийн оролцоог



хангуулах, үйлчилгээний байгууллагууд, багийн Засаг дарга, багийн ИНХ-ын дарга нарын ажлын тайланг тавиулах, үйлчилгээний хүртээмж чанар, ил тод шуурхай байдлыг иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг үндэслэн үнэлэх, түүнд тулгуурлан үйл ажиллагааг нь сайжруулах, иргэний танхимаар, утас, цахим хаяг зэрзг орон нутагт байгаа бүхий л арга хэрэгслээр иргэдийн санал гомдол, өргөдөл хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, хариу өгөх ажлуудыг хэвшүүлэхэд чухалчлан анхаарч ирлээ.

“НӨУБ-ын чадавхийг бэхжүүлэх нь” төсөлтэй хамтран аймаг, сумдын ИТХ-ын төлөөлөгчдийн сургалтыг 3 ээлжээр 9 хоногийн хугацаанд төлөөлөгчдийн 85%-ийн ирцтэй, эмэгтэй төлөөлөгчдийн сургалтыг 2 өдөр 90% -ийн ирцтэйгээр тус тус зохион байгуулж, 470 төлөөлөгчид оролцуулан, сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга нарыг УБ хотод МНУХ, КАС-ийн сургалтанд хамруулаа.



Мөн Хяргас, Завхан сумын ИТХ-аас төлөөлөгчдөө Удирдлагын академийн сургалтанд, 7 сумын ИТХ-аас төлөөлөгчдөө МНУХ-ны, Улаангом сумын ИТХ-аас төлөөлөгчид, багийн ИНХ-ын дарга нараа “Мерси Кор” ОУБ, УНАСДЦГ-тай хамтран байгаль орчныг хамгаалах, Давст, Баруунтуруун, Өмнөговь, Өлгий сумын ИТХ-аас төлөөлөгчдөө хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах сургалтуудыг бие даан зохион байгуулж төлөөлөгчдийг сургах, дадлагажуулах, туршлага судлуулах ажлыг хийлээ.



- Аймгийн ИТХ, тэргүүлэгчид, ажлын алба 2014 онд 144 ажил арга хэмжээг зохион байгуулж

хийхээр төлөвлөснөөс 142 нь биелсэн, 2 ажлыг 2015 онд шилжүүлж, 99%-ийн гүйцэтгэттэй, цаг үеийн шаардлагаар 5 ажил арга хэмжээг нэмж хийлээ. Аймгийн ИТХ, ажлын албаны 2014 оны жилийн ажлын төлөвлөгөөнд туссан нийт ажлыг сарын хуваарьт оруулж холбогдох талуудад хүргүүлэн танилцуулж, тэргүүлэгчид, хурлын хороод болон ажлын албанаас зохион байгуулах асуудлаар нь ялгаж ажилтан бүрийн үр дүнгийн гэрээнд тусган эз энжүүлсэн нь төлөвлөгдсөн ажил арга хэмжээнүүд хэрэгжих үр дүн нь дээшлэхэд нөлөөллөө.

- 2014 онд аймгийн ИТХурал, ажлын алба хамтдаа 306,6 сая төгрөгийн, төлөөлөгчдийн үйл


ажиллагаанд 123 сая, нийт 429,6 сая төгрөгийн төсөвтэй ажилласны 32,9% нь ажлын албаны ажилтнуудын цалин урамшуулалд, 19,2% нь дотоод болон гадаад томилолтонд, 11,4% нь тээвэр шатахууны зардалд, 1,2% нь бичиг хэрэгт, 1,1% нь шуудан холбоонд, 5,9% нь хуралдааны зардалд, 2,4% нь намын суудалд, 2,1% нь мэдээлэл сурталчилгаанд, 14,3% нь нэг удаагийн зардалд, 1,6% нь ГХУСАЗЗөвлөлийн, 1,4% нь цагаатгалын комиссын ажилд, 1,2% нь ном хэвлэлд, 3,1% нь эд хогшил худалдан авахад, 2,2% нь төлбөр хураамж болон бусад зориулалтаар тус тус зарцуулагдсан байна. Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдэд оролцооны байдлыг нь харгалзан улиралд 90000 хүртэл төгрөгийн урамшуулал олгож, Хурлын хороодын ажлын үеэр цай хоол, бусад шаардлагатай үйлчилгээг үзүүлж ажиллах нөхцлийг нь бүрдүүлж ирлээ.

- Аймгийн ОНӨ-ийн албыг ИТХ-ын ажлын албаны бүтцэд нэгтгэж, мэргэжилтнүүдийн ажлын

байрны тодорхойлолтыг шинэчлэн мөрдүүллээ. Орон нутгийн өмчийн асуудлыг



Тэргүүлэгчдийн 13 удаагийн хурлаар хэлэлцэж 26 тогтоол, 2 тэмдэглэл гарч, тогтоолыг 95,1% -аар биелүүлж,



орон нутгийн өмчит байгууллагуудын илүүдэлтэй, ашиглалтгүй хөрөнгийн асуудлыг

шийдвэрлэж ажилласан байна. Үүнд: 259,7 сая төгрөгийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах, 129,7 сая төгрөгийн хөрөнгийг актлах, 252,5 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, 65,9 сая төгрөгийн хөрөнгийг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлэх шийдвэр гаргаж сум, байгууллагуудаас ирүүлсэн хөрөнгийн асуудлаарх саналыг хууль журмын дагуу бүрэн шийдвэрлүүллээ.

Орон нутгийн илүүдэлтэй ашиглалтгүй хөрөнгийг худалдан борлуулж аймгийн орон нутгийн төсөвт 45.0 сая төгрөгийн орлого оруулахаас 198 сая төгрөгийн орлого төвлөрүүлж худалдан борлуулах үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулав.

Орон нутгийн өмчит байгууллагуудын өмч хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, ажлын байр бий болгох зорилгоор иргэд аж ахуйн нэгжтэй 3 талт түрээсийн гэрээг байгуулан ажиллаж 12 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт оруулж хөрөнгийн ашиглалтыг сайжруулж, өмнөх оны 950,0 мянган төгрөгийн авлагыг барагдууллаа.

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2013 онд ашиглалтанд орсон 5 барилга, байгууламж, эд хөрөнгүүдийг орон нутгийн өмчид бүртгэж, ашиглалтыг сайжруулах зорилгоор хуульд заасан арга хэлбэр, нөхцөлийн дагуу орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн 2 газар байгуулан, менежментийн үр дүнг харгалзан 1 барилгыг хувьчлах, 1 байгууламжийг дуудлага худалдаагаар худалдах зэрэг шийдвэрийг гарган хэрэгжүүллээ.

Орон нутгийн өмчийн холбогдолтой дүрэм журмуудыг шинэчлэн боловсруулж “Орон нутгийн өмчийн журам, заавар”-ыг эмхэтгэл болгон хэвлүүлж сум болон төсөвт байгууллагуудад хүргүүлэн сумдын хурал, өмч хамгаалах байгууллагын зөвлөлийн эрх үүрэг, хариуцлагыг өндөржүүлэн, журмын хэрэгжилтэнд хяналт тавьж байна.

Дуудлага худалдааны зар мэдээг урсдаг самбар, гудамжны LED дэлгэц, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дүрстэйгээр нээлттэй явуулж, иргэд аж ахуйн нэгж байгууллагад мэдээллийг шуурхай хүргэж ил тод байдлыг хангаж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийн “онлайн” нэгдсэн системийг бүрдүүлж, цахим мэдээллийн нэгдсэн санд холбогдлоо.

- 2014 онд аймгийн ИТХ-аас 8 төрлийн ном сурах бичиг захиалан авч, 2013-2014 оны

аймаг, сумын ИТХ-ын онцлог шинэ ажлаар ширээний календарь хэвлүүлж , бичмэл сэтгүүлийн 4 дугаар, Онцлох мэдээний 10 дугаарыг тус тус бэлтгэн гаргаж аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, сумдын ИТХ, бусад холбогдох байгууллагуудад хүргүүлж гарын авлагаар хангалаа.



Орон нутгийн телевизүүдээр аймгийн ИТХ-ын ажлын алба, төлөөлөгчдөд үйл ажиллагаагаа сурталчлах цагийн хуваарь гаргаж орон нутгийн МВС,САМА телевизүүд, “Увсын өнгө” сонинтой хамтран

ажиллах гэрээ байгуулан ажилласнаар 24 төлөөлөгч тойрогтоо болон аймгийн хэмжээнд хийж хэрэгжүүлсэн ажлаа мэдээлэн сурталчилж 7 төлөөлөгчид сонины нүүр гаргаж ажлаа тайлагнан, сумаас сонгогдсон 10 төлөөлөгч тойрогтой “Төлөөлөгчийн нэрэмжит өдөрлөг” зохион байгууллаа.

2014 оны 10-р сард “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төсөл, МНУХ-той хамтран www.khural.mn цахим хуудасны 2 сургагч багшийг бэлтгэж, орон нутагт сургалтыг зохион байгуулж, цахим сүлжээ бүхий 18 сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, Иргэний танхимын ажилтануудыг хамруулан 2014 оны 11-р сараас эхлэн сумдын ИТХ-ууд нэгдсэн цахим хуудсанд мэдээ мэдээллүүдээ тогтмол оруулдаг болж аймаг, сумдын ИТХ-ын дунд зарласан болзолт уралдаанд аймгийн ИТХ шалгарч 1 сая төгрөгөөр шагнууллаа.

Аймгийн ИТХ-ын ажлын алба нь Mass агентлагийн дэргэдэх www.ontslokh.mn цахим хуудастай хамтран ажиллаж мэдээллээ сурталчилж байна.

"Нутгийн удирдлага" сэтгүүлийг өргөнөөр захиалан ашиглаж, түүнд 8 сумын ИТХ, ЗДТГ ажлын туршлага, танилцуулгаа нийтлүүлж, багийн ИНХ-ын дарга, аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгч бүр харилцан туршлага мэдээллээ солилцох, гарын авлага болгож ашиглаж байна.

Аймгийн иргэний танхимаар зохион байгуулсан 5 удаагийн хэлэлцүүлэгт 330 гаруй хүн оролцож, 4 удаагийн нэвтрүүлэг бэлтгэн орон нутгийн телевизээр иргэдэд хууль зрх зүйн сурталчилгаа явууллаа. Хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэн гэр бүлийн хүчирхийлэлгүй аймаг болох, төлбөр тооцоог иргэдээс амар хялбар байдлаар авах, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах асуудлаар тогтоол гаргалаа.



2015 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийх ажил, үйлчилгээ, Увс аймгийн хөгжлийн хөтөлбөр батлахтай холбогдуулж онлайн санал асуулга явуулж 7200 гаруй иргэний саналыг авлаа. Аймгийн иргэний танхимд шуурхай мэдээлэл хүлээн авах, дамжуулах цогц систем ажиллаж байна.

- Аймгийн Засаг даргын зөвлөл, ИТХ-ын Тэргүүлэгчид бодлого зорилт, үйл ажиллагаагаа

уялдуулах, ЗДТГ-тай хамтран тухайн жилийн турш явагдах сургалт, семинарын нэгдсэн хуваарийг гарган хамтран зохион байгуулж мөрдүүлэх, Засаг даргын мөрийн хөтөлбөр, 2014 онд тавьсан гол зорилт болох ”Төрийн үйлчилгээг иргэн бүрт хүргэх” ажлын хэрэгжилт, үр дүнг Хурлын хороод 2 удаа шалган эрчимжүүлэх, санал дүгнэлт гаргах, шаардлагатай асуудлаар 4 удаа асуулга тавьж, мэдээлэл хариуг нь Хурлын хуралдаан, Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн үнэлэлт дүгнэлт өгөх, энэ асуудалтай

холбоотойгоор 2 удаа тогтоол шийдвэр гаргах ,төлөөлөгчид, ажлын алба ЗДТГ-тай хамтарсан ажлын хэсгийг 2 удаа томилон сум, байгууллагуудад ажиллуулж сумын ажилтай танилцаж, зөвлөмж, чиглэл өгч, цаг үеийн ажлаар иргэдтэй уулзаж санал хүсэлтийг сонсох, ИТХ-аас баталсан удирдамжийн дагуу сумдын ИТХ, ЗДТГ, иргэний танхимын ажилд хяналт шинжилгээ үнэлгээ хийж ажлыг зохион байгууллаа.

- Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, Хороод, ажлын албанаас нийт сумын ИТХ-ын ажилтай

2 удаа, багийн ИНХ-ын 60%-д нь хүрч ажиллан зөвлөмж өгч, оны төгсгөлд нийт сумдын ИТХ-ын ажилд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ажлыг нь дүгнэлээ. Энэхүү дүнг үндэслэн аймгийн шилдэг сумын ИТХ /дарга/ 3, нарийн бичгийн дарга 3, иргэний танхимын ажилтан 3, Хурлын ажлын албаны шилдэг ажилтан нэг, аймгийн тэргүүний багийн ИНХ нэг, аймгийн ИТХ-ын шилдэг төлөөлөгч гурван хүнийг тус тус шалгаруулж аймгийн ИТХ-ын хүндэт медальон, дурсгалын зүйлээр шагнаж урамшуулан, сум, багийн ИНХ, иргэний танхимын ажлыг боловсронгуй болгож сайжруулах тухай аргачилсан зөвлөмж гарган сумдын ИТХ-д хүргэв.

Сумдын ИТХ-ын ажилд өгсөн чиглэл, зөвлөмжүүдийн хэрэгжилтийг нэгтгэн үзвэл:



Хурлын хуралдаан 56 удаа, Тэргүүлэгчдийн хурал 277 удаа, багийн ИНХурал 318 удаа хуралдаж орон нутгийн цаг үеийн тулгамдсан асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэжээ. Сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар 955 асуудал хэлэлцэн 2390 заалт бүхий 1101 тогтоол гаргаж, сумын дүрэм, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг зарцуулах журам, нийтийн зар мэдээний журам, төлөөлөгчийн ёс зүйн дүрэм, сумын ИТХ-ын үйл ажиллагааны журам, сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хоршоо хөгжүүлэх дэд хөтөлбөр, газарт тариалан дэмжих хөтөлбөр болон бусад асуудлаар 32 журам, төлөвлөгөө батласан байна.

Сумдын ИТХ-ын Хороод 107 удаа хуралдаж, 96 санал дүгнэлт гаргаж, тогтоол шийдвэрт тусгуулж, төрийн байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмж, “Үдийн цай” хөтөлбөр, гал тогоо бүхий газруудын эрүүл ахуй, орон нутгийн өмч, хүнс, архи, тамхины зэрэг хуулиудын хэрэгжилтэнд 54 удаа хяналт шалгалт хийж 58 зөвлөмж өгчээ.

Төлөөлөгчдийн өдөрлөг, ИТХ-ын нээлттэй хаалганы өдрийг 13 сумын ИТХ зохион байгууллаа.

Сумын ИТХ-аас санаачлан зохион байгуулсан онцлог ажлаас дурьдвал:

Өндөрхангай сумын ИТХ нь Хурлын төлөөлөгчид, иргэдийн оролцоотой хяналтын зөвлөл, Зүүнхангай сум иргэний зөвлөл байгуулан ажиллуулж хөрөнгө

оруулалт, бүтээн байгуулалтын ажилд хяналт тавиулсан, Зүүнхангай, Өмнөговь сумын ИТХ сумын 90 жилийн ой угтаж 90 бүтээлч ажил хийх хөдөлгөөн өрнүүлж, иргэдийн идэвхтэй оролцоонд тулгуурлан сумын төвийн өрхүүдийн хашааг жигдрүүлэн шинэчлэж, бүтээн байгуулалтын олон ажлыг бага зардлаар хийлээ.

Зүүнхангай сумын иргэний танхим хэлэлцүүлэг, багийн ИНХ-ын үеэр иргэдийн гаргасан саналын дагуу Засаг даргын тушаал, баасан гарагт архи худалдахгүй байх шийдвэр гарган мөрдүүлэн, хэлмэгдэгсдийн дурсгалын хөшөө босгож, ОНХС-ийн хөрөнгөөр үлийн цагаан оготно устгах, худаг гаргах, малжуулах ажлуудыг хийсэн, Наранбулаг сумын ИТХ сумын Засаг даргад асуулт тавьж хариуг авч хэлэлцсэн, Цагаанхайрхан сум “хөдөлгөөнт зар” ажиллуулан хууль тогтоомжийг сурталчилж, Өмнөговь, Баруунтуруун сум нээлттэй хуралдаан хийж шууд утас ажиллуулан иргэдийн саналыг авсан байна.

Багийн ИНХ 318 удаа хуралдаж 17272 иргэн оролцож 644 асуудал хэлэлцэж 900 заалт бүхий 433 тогтоол, 59 журам гаргасан. Иргэдийн дунд 184 хэлэлцүүлэг, 72 санал асуулга явуулж 1288 иргэн санал гаргаснаас 480 саналыг захирамж, тогтоол, тушаалд тусгаж 34 саналыг шийдвэрлүүлэхээр холбогдох албан тушаалтанд уламжилжээ.

- Аймгийн ИТХ-аас гаргасан сүм хийдийн ажиллах шинэчилсэн журмын хэрэгжилтэнд үзлэг

явуулж, христийн шашны 2 сүмийн үйл ажиллагаа явуулах эрхийг 1 жилээр сунгав. МНУХ-ны аймгийн салбараас холбооны гишүүн байгууллагуудын дунд явуулах зохион байгуулалт, санхүү аж ахуй, мэдээлэл сурталчилгааны ажилд байнга анхаарч идэвхтэй оролцож ирсний дээр аймгийн ИТХ-ын дэргэд ахмад зөвлөхүүдийн зөвлөл, иргэний зөвлөлүүдийг шинээр зохион байгуулж ажилд нь бүх талын дэмжлэг үзүүлж, Ховд аймагт болсон Иргэний зөвлөлүүдийн бүсийн сургалтанд аймгийн иргэний зөвлөлийн 3 гишүүнийг оролцууллаа.



МНУХ, Мерси Кор ОУБ-ын хамтарсан сумын хөгжлийн хөтөлбөр боловсруулах төсөлд 2013 онд шинээр 6 сум хамрагдсанаас 4 суманд хөгжлийн хөтөлбөр боловсруулах ажлыг дуусгаж, Сагил сум төслөөс гадуур бие даан хөгжлийн хөтөлбөрөө боловсруулж, Өлгий суманд уг ажлыг үргэлжлүүлэн хийж байна.

Аймгийн ИТХ-ын батласан “Хөндөгдсөн газарт нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгж, нөхөрлөлийг сонгон шалгаруулах, үйл ажиллагаанд нь хяналт тавих” журмын дагуу 12 аж ахуйн нэгж, 2 нөхөрлөл Өмнөговь, Тариалан сумын 46,8 га талбайд нөхөн сэргээлт хийлээ.

Аймгийн ИТХ-ын хуралдаанаар хувийн хэвшил, иргэний байгууллагыг дэмжих, хамтран ажиллах чиглэл, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг баталлаа.

Аймгийн ИТХ-ын удирдлага, зохион байгуулалттайгаар Улсын физикийн 27-р олимпиадыг Улаангом хотод зохион байгуулж физикийн ухааны доктор, эрдэмтэд, багш, сурагчид, 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн нийт 250 гаруй хүн оролцсоноос Увс аймгийн багш нар 1 мөнгө, 2 хүрэл, 2 сурагч мөнгөн медаль хүртлээ.

Хоёр. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаан

2014 онд аймгийн ИТХ-ын хуралдааныг 2 удаа 87,8 хувийн дундаж ирцтэй хуралдуулж, 13 асуудал хэлэлцэж 83 заалт бүхий 18 тогтоол шийдвэр гаргаж давхардсан тоогоор төлөөлөгчид 263 санал шүүмжлэл гаргаснаас 32 санал хурлын шийдвэрт тусгаж бусад санал шүүмжлэлүүдийг холбогдох байгууллагуудын зорилт, ажлын төлөвлөгөөнд тусгуулахаар хүргүүллээ.

Аймгийн ИТХ-ын 7-р хуралдаанаар 7 асуудал хэлэлцэж 39 заалт бүхий 10 тогтоол гаргалаа. Аймгийн концессийн зүйлийн жагсаалт, хувийн хэвшил, иргэний байгууллагыг дэмжиж, хамтран ажиллах чиглэлийг батлаж, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж, орон нутгийн татварын бааз суурийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай тогтоол гаргаж 2014 оны орон нутгийн төсөвд нэмэлт оруулаа.

Концессын гэрээгээр дулааны 2-р станцын дулаан дамжуулах 2 төвийг хэрэглэгчидтэй холбох гадна дулаан, цэвэр, хэрэглээний халуун усны шугамын ажлыг 1,5 тэрбум төгрөгөөр гүйцэтгэж ашиглалтанд оруулснаар 30 байгууллага, 730 айл өрхийг дулаан, хэрэглээний халуун усаар найдвартай хангаж, иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүллээ. Баруунтуруун сумын төвийг нэгдсэн халаалтын системд холбох ажлыг концессын гэрээгээр гүйцэтгэж байна.



Аймгийн ИТХ-ын 1 төлөөлөгч төрийн албанд шилжсэн, 2 төлөөлөгч огцорсон тул аймгийн ИТХ-ын 3 тойрогт нөхөн сонгууль 4-р сард явагдаж аймгийн ИТХ-ын 3 төлөөлөгч сонгогдлоо.

Аймгийн ИТХ-ын 8-р хуралдаанаар аймгийн ИТХ-ын ажлын тайлан, 2014 оны эдийн засаг, нийгмийн зорилтын биелэлт, 2015 оны эдийн засаг, нийгмийн зорилт, ОНХС-аар хийгдэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил, 2013 оны төсвийн гүйцэтгэл, 2014 оны төсвийн тодотгол, 2015 оны төсөв, аймгийн газар зохион

байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах бодлогын хэрэгжилтийн тухай 6 асуудал хэлэлцэн 44 заалт бүхий 8 тогтоол гаргалаа.

Аймгийн ИТХ-ын 2014 оны ажлын тайланг "Хангалттай ажилласан" гэж, аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн 2014 оны зорилт, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг "Хангалттай" гэж тус тус дүгнэн, аймгийн эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх асуудлаар 90 зорилт дэвшүүлж, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх бүтээн байгуулалтын ажлын 45 төсөл, арга хэмжээний жагсаалтыг батлав.

Аймгийн ИТХ-ын өмнөх хуралдаан дээр төлөөлөгчдөөс гаргасан 172 асуудал хөндсөн санал шүүмжлэлийг холбогдох 13 байгууллагад албан тоотоор хүргүүлснээс 8 байгууллага хариу ирүүлснийг санал гаргасан төлөөлөгч бүрт, мөн холбогдох хурлын хороодод мэдээлэх, цахимаар хүргүүлж, цаасаар хзвлэсэн нэгтгэлийг нь хороодын ажлын танхимд тавьж танилцууллаа.

Хуралдааны бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг гаргаж, зарыг урсдаг самбар, орон нутгийн

хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж, хуралдааны явцыг орон нутгийн 2 телевизээр шууд болон хэсэгчлэн дамжуулан нэвтрүүллээ.

Аймгийн ИТХ-ын даргын баталсан удирдамжаар аймгийн ИТХ-ын 39 төлөөлөгч Тэс, Давст, Зүүнговь, Өмнөговь, Тариалан, Ховд, Бөхмөрөн, Баруунтуруун, Улаангом, Сагил, Наранбулаг, Цагаанхайрхан, Өндөрхангай, Зүүнхангай, Түргэн, Хяргас, Малчин сумдад ажиллаж иргэдтэй уулзалт, ярилцлага хийж, ажлын тайлангаа танилцуулж, тулгамдаж буй асуудлыг судлан санал хүсэлтийг нь сонсож, төлөөлөгчид дундажаар 7 өдөр сум, багт ажиллан шаардлагатай асуудлуудыг Хурлын хороод, Тэргүүлэгчдийн хуралд хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх арга хэмжээ авлаа.

2014 онд аймгийн ИТХ гадаад хамтын ажиллагааны харилцааны үр дүнг дээшлүүлэхэд

анхааран аймгийн ИТХ-ын 12 төлөөлөгч Тайваний Тайбэй хотод ажиллаж төр захиргааны болон эрүүл мэнд, боловсрол, соёл, модон эдлэл, чацаргана боловсруулах салбарын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, туршлага судалж айлчлал хийлээ. Энэ үеэр Увсын чацарганы тосны дээжийг шинжилгээний лабораторит шинжлүүлж дэлхийн стандартад нийцсэнээр дэлхийн зах зээлд худалдаалагдах зам нээгдлээ.

Аймгийн ИТХ-ын 6 төлөөлөгч Япон улсын Кюүко мужийн Фүкоүка хотод айлчилж мужийн УИХ-ын дарга, удирдлагуудтай уулзаж, хорт хавдар судлалын институт, роботын үйлдвэр, төмөрлөг, нүүрс боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцаж Өргөмжит консултай уулзаж, Увс аймаг, Кюүко мужийн УИХ-ын хоорондын хамтын ажиллагааны эхлэлийг тавилаа.

Аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд, төлөөлөгч Б.Гомбосүрэн, ГХБХБГ-ын дарга Г.Отгонболд нар Шинжаан Уйгарын Өөртөө Засах Орны Алтай аймагт айлчилж Алтай орчмын бүс нутгийн эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны "Торгоны зам" олон улсын хуралдаанд оролцож, аялал жуулчлал, хот байгуулалт, цэцэрлэгжүүлэлт, боловсруулах үйлдвэртэй танилцаж, Засгийн газар, газар тариалан, МАА-н корпорацийн удирдлагуудтай уулзаж эдийн засаг, нийгмийн харилцааг өргөжүүлэх, хамтран ажиллах санал солилцож санамж бичигт гарын үсэг зурлаа.

Аймгийн ИТХ-ын ажлын албаны хамт олон Тува улсын Дээд хурлын дарга Кан-Оол Тимурович Даваагийн урилгаар Кызыл хотод хоёр талын хамтын ажиллагааны гэрээний хүрээнд туршлага солилцох албан ёсны айлчлал хийж Тува үндэстний урлаг, соёл, аялал жуулчлал, хүнсний үйлдвэрлэлтэй танилцаж "Тува Экспо-2014" үзэсгэлэн худалдаанд оролцлоо.

Тува–Монголын ард түмний найрамдалт харилцааг бэхжүүлэх, Увс аймаг ба Тува улсын бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлэн Увс аймгийн ЗДТГ, ИТХ-аас санаачлан Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжилснаар ОХУ-ын тусгаар тогтнолын баярын өдрийг тохиолдуулан ОХУ-ын Тува улсын Засгийн газрын Тэргүүн Шолбан Валерьевич Кара-оолыг Монгол улсын төрийн дээд шагнал "Алтан гадас" одонгоор шагнасныг аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд Кызыл хотноо суугаа Монгол улсын Ерөнхий консул Д.Ганболд нар Тува улсын Засгийн газрын ордонд гардуулж өглөө.

ОХУ-ын Тува улсын Дээд хурал ба Увс аймгийн ИТХ-ын хамтын ажиллагааны хүрээнд Тува улсын Дээд хурлын төлөөлөгчид, Кызыл хотын сургуулийн захиралууд Улаангомд хүрэлцэн ирж ахлах ангийн сурагчдын дунд орос хэлний олимпиадыг зохион байгуулж, шалгарсан 23 сурагчид багш нарын хамт Кызыл хотод зохиогдсон орос хэлний олимпиадад оролцож, аялал хийлээ. Улаангом сумын 3,4-р сургууль Кызыл хотын 12-р сургуультай, Чандмань эрдэм, Увс Эрдэм сургуулиуд Кызыл хотын 2-р сургуультай хамтран ажиллахаар гэрээ байгууллаа.

Тува улсын Дээд хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга Маргарита Михайловна, Тува улсын Дээд хурлын төлөөлөгч нар Увс аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч М.Ганбаатар, Э.Баатарсан, ҮХААЖДҮ-ын газрын дарга Ж.Александр, жижиг дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгч нартай уулзаж Тува улсын бизнесийн 20 гаруй төлөөлөл оролцсон бизнес эрхлэгчдийн уулзалт хийж, харилцан туршлага судлав. Хан-Уул дүүргийн ИТХ-тай Хяргас сум, ОХУ-ын Красноярскийн хязгаарын Курагино районтай Улаангом сум, ОХУ-ын Тува улсын Кызыл хоттой Сагил сум хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

Говь-Алтай аймагт зохион байгуулагдсан Баруун бүсийн Нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгуультан, ажилчдын спортын 3-р наадамд Увс аймгийн ИТХ-ын

даргаар ахлуулсан баг тамирчид спортын 6 төрлөөр амжилттай оролцож 1-р байранд эзлэж шилжин явах цомоор шагнагдлаа.

Гурав. ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаан

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлыг сард 2-оос доошгүй хуралдуулж 2 асуудлыг

хэлэлцүүлэхээр төлөвлөснөөс бүгд 20 удаа, 80%-ийн дундаж ирцтэй хурал хийж 107 асуудал

хэлэлцэж 383 заалт бүхий 110 тогтоол, 16 тэмдэглэлээр шийдвэр гаргаж хэрэгжүүлэх ажлыг зохион байгууллаа.

Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцсэн асуудлын дотор аймгийн биеийн тамир спортыг хөгжүүлэх хөтөлбөр, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах аймгийн дэд хөтөлбөр, сумдын худалдан авах ажиллагааг дүгнэх, ОНӨҮГ ажиллуулах, худалдааны төвийн ажиллах, орон сууцны болон үйлчилгээний барилгын орчны тохижилтын, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийг камержуулах, ИТХ-ын дэргэдэх ахлах зөвлөхүүдийн ажиллах, аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөлийн ажиллах, Мини захыг менежментийн гэрээгээр ажиллуулах этгээдийг сонгон шалгаруулах журмуудыг батлаж, бэлчээрийн менежмент, “Том төрөөс ухаалаг төр рүү” хэлэлцүүлэг, ҮАБЗ-ийн зөвлөмжийн мөрөөр зохион байгуулсан ажлын үр дүнгийн тухай сонсгол, Цахилгаан түгээх сүлжээ компани, “Хатан түрүү” компани, Улаангом хотын цэцэрлэгжүүлэлт, тохижилтын газар, аймгийн эрүүл мэндийн газрын дарга нар болон Давст сумын ИТХ-ын даргын сонсголыг хэлэлцэж зохих шийдвэрийг гаргалаа.

Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэх аливаа асуудлыг урьдчилан иргэний танхимаар холбогдох талуудыг оролцуулсан хэлэлцүүлэгт оруулж, гарсан саналыг хурлын хороон дээр нэгтгэн эрэмблэж санал дүгнэлт гарсны дараа тэргүүлэгчдийн болон хурлын хуралдаанд оруулдаг хзвшил тогтож төлөвшлөө.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаас иргэдийг төрийн дээд шагнал, одон медальд 196 хүнийг тодорхойлсноос Гавьяат цолоор 1, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 6, Алтан гадас одонгоор 86, Хөдөлмөрийн хүндэт медалиар 67, нийт 160 хүн буюу 81,6% нь шагнууллаа.

Төрийн шагнал	2014 онд тодорхойлон ЕТГ-т уламжилсан тоо	2014 онд шагнагдсан нийт тоо
Алдарт эх 1-р одон	60	60
Алдарт эх II одон	302	297
Нийт, Алдарт эх	362	357 98,6%

одон		

Мөн аймгийн ИТХ-аас баяр ёслол тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан НӨУБ, нутгийн захиргааны байгууллагын ажилтнууд, бүх салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид, хувираа хөдөлмөр, бизнес эрхлэгчдийн төлөөлөл болох 39 хүнийг Аймгийн ИТХ-ын "Хүндэт өргөмжлөл"-өөр, 20 хүнийг “Баярын бичиг”, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.

Аймгийн ИТХ-д бусад байгууллагаас 440 албан бичиг тоот ирсний 380-ыг судлан шийдвэрлэж, хариу өгч, үлдэж байгаа 30 нь судлагдах шатанд, аймгийн ЗДТГ-т 30 бичгийг шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн, аймгийн ИТХ-д иргэдээс бичгээр 31 өргөдөл гаргасныг судлан шийдвэрлэж хариу өглөө.

- Хурлын төлөөлөгчид Хороо болон ажлын хэсэгт давхардсан тоогоор 104 удаа ажиллаж,



хороо тус бүр 2-4 хяналт, боловсруулалтын ажил хийж, Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг бэлтгэх, хуралдааны бэлтгэл хангах асуудлаар 26 удаа хуралдаж, хяналт шалгалтын ажил явуулах, судалгаа хийж санал дүгнэлт гаргах, баримт бичиг, шийдвэрийн төсөл боловсруулах ажлыг 14 удаа зохион байгууллаа. Жишээ нь:

а/Төсөв санхүү эдийн засгийн хороо: Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтөнд нөлөөлж буй хүчин зүйлс, үнийн хөөрөгдлөөс урьдчилан сэргийлэх, бодит өсөлтийг тогтоох асуудлаар Статистикийн хэлтэс, аймгийн ЗДТГ-ын хөгжлийн бодлогын хэлтэс, Улаангом сум, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгтэй хамтран Улаангом сумыг 7 хэсэгт хувааж 100 иргэн, 5 хүнсний бөөний төв, 20 хүнсний дэлгүүр, 8 тээвэрчдээс судалгаа авч өргөн хэрэглээний барааны үнийн бодит өсөлтийг тогтоож, Тэргүүлэгчдийн тэмдэглэлээр дүгнэлт гаргаж ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэст 1 чиглэл, сумын Засаг дарга нарт 2 даалгавар өгсөн.

б/ Нутгийн удирдлага, хамтын ажиллагааны хороо: Багийн ИНХ-ын ажлын нөхцөл боломжийг сайжруулах талаар 7 заалттай дүгнэлт гаргаж багийн ИНХ-ын жилийн төсвийн төсөл боловсруулж аймгийн ЗДТГ-т хүргүүлэн, Улаангом сумыг 2016 он хүртэл хөгжүүлэх ажлын төсөөлөл, цаашид хотын статустай болгох нөхцлийг бүрдүүлэх, хот төлөвлөлтийн тухай, Улаангом сумын ИТХ, иргэний танхим, Хотын хөгжил, цэцэрлэгжүүлэлтийн газрын үйл ажиллагаатай танилцаж 16 заалт бүхий дүгнэлт гаргаж хүргүүллээ.

в/ Байгаль орчин экологийн тэнцвэрт байдлын хороо: Өмнөговь, Тариалан сумдын нутагт гар аргаар алт олборлодог иргэд болон хөндөгдсөн газрын нөхөн сэргээлт, Улаангом суманд түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын

байдал, эвдэгдсэн газар, түүний нөхөн сэргээлтийн ажил, БОГ, УТХГНХЗ, ХХЦГ, ҮХААГ-ын ажлын явц, зохион байгуулсан онцлог ажил, бэрхшээлтэй асуудлуудтай явж танилцан Тэргүүлэгчдийн хурлын 2 тогтоол гаргаж,1журам батлаж, аймгийн Засаг даргад 4, Улаангом сумын Засаг даргад 6 үүрэг өгч, 3+ дүгнэлт гаргасан.

г/ Хүний хөгжил, нийгмийн асуудлын хороо: Ном, Авьяас хөтөлбөрийн тайлан, аймгийн хөдөлмөр эрхлэлтийн байдал, эрүүл мэндийн байгууллагын сонсголтой холбоотой судалгаа хийж, дүгнэлт гаргах зэрэг ажлыг зохион байгууллаа.

д/ Хууль эрх зүй, дотоод хяналтын хороо: Аймгийн ИТХ-ын төлөөлөгчийн нөхөн сонгууль, орон нутгийн татварын бааз суурийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээ, аудитын газрын улирлын ажлын тайлан мэдээ, Улаангом сумын гэмт хэргийн гаралтын ажиллагаа, аймгийн эдийн засаг нийгмийн 2015 оны зорилт, ОНХС-аар хийгдэх хөрөнгө оруулалт, бүтээр байгуулалтын ажлын жагсаалттай танилцан цаашид анхаарах асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргав.

Дөрөв. Хяналт шалгалтын ажил

Аймаг, сумдын засаг дарга нарын үйл ажиллагааны хөтөлбөр, ажлын тайланг хэлэлцэж, үйл ажиллагаанд нь үнэлэлт дүгнэлт өгөх явдал хэвшиж, хурлын хороод, 7 ажлын хзсэг байгуулан ажиллуулах, асуулга тавих, хөндлөнгийн болон дотоод хяналтын байгууллагуудад захиалга өгч хяналтын чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Аймгийн ИТХ-ын хуралдаан дээр гарсан санал шүүмжлэл, иргэд байгууллагаас ирүүлсэн хүсэлт мэдээлэл, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээс гаргасан шийдвэрүүдтэй холбоотойгоор Аудитын газартай хамтран аймгийн 2013 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Улаангом сумын 7-р цэцэрлэг, Баруун бүсийн эрчим хүчний систем, “Увс-АЗЗА” ХК-ний 2012, 2013 оны санхүүгийн үйл ажиллагаа, Цагаанхайрхан сумын төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаа, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэсийн Халамжийн сангаас 2011, 2012 онд ахмад настанд үзүүлэх тусламж хөнгөлөлтийн зарцуулалт, олголт, аймгийн эдийн засаг нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэнд нийцлийн болон гүйцэтгэлийн аудит хийлгэлээ.

Аймгийн ИТХ-ын ажлын албанаас авилгатай тэмцэх, шударга ёс, ил тод байдлыг хангах талаар 2014 онд хийх ажлын төлөвлөгөө гарган, шударга ёс, ил тод байдлыг бэхжүүлэх "Ил тод байдлын самбар" ажиллуулж, НӨУБ-ын 504 албан тушаалтны Хөрөнгө орлогын мэдүүлгийг гарган Авлигатай тэмцэх газарт цахимаар хүргүүллээ.

Бусад хяналт шалгалтын ажлуудын дүн мэдээг Хурлын хороо, ГХУСАЗСЗ-ийн ажлын дүнд тусгасан болно.

Тав. Бусад ажил


- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аймгийн салбар зөвлөл нь хүний эрхийг хангах, гэмт

хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжихэд түлхүү анхаарч гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөлийг судлах, холбогдох арга хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг татан оролцуулах, сум, багуудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хурал зөвлөгөөнийг хамтран зохион байгуулж 29 ажил хийхээр төлөвлөснөөс удирдлага зохион байгуулалтын хүрээнд 11 ажил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны чиглэлээр 5 ажил, архидан согтуурах, тамхи, мансууралтай тэмцэх чиглэлээр 4, тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлд 6 ажлыг тус тус хийж гүйцэтгэлээ. Үүний үр дүнд аймгийн хэмжээнд архидан согтуурах танхайрах явдал буурч, тамхигүй цэвэр орчныг бүрдүүлж, иргэд гэмт хэрэг үйлдэх, түүний хор уршиг, хүлээх хариуцлагын талаар зохих мэдлэгтэй болж, гэмт хэрэг гарсан даруй холбогдох газарт түргэн шуурхай мэдээлэхэд ахиц дэвшил гарч архи, согтууруулах ундаа худалдаалах цэгүүдэд тавих хяналт нэмэгдлээ. Гэвч Тува улсад 226 малын хулгайн гэмт хэрэгтэн суллагдсан, хилийн хамгаалалтын инженерийн байгууламж барих боломжгүй байгалийн нөхцөлүүд хилийн бүсэд олон байгаа, малчид хилд тулгаж малаа хариулж ирсэн уламжлал арилахгүй байгаа нь хил дамнасан малын хулгай нэмэгдэхэд нөлөөлж байна.

2013-2014 онд Увс аймагт гарсан гэмт хэргийн тоог харьцуулан үзүүлвэл:



Нутаг дэвсгэртэй сахилга дэг журмыг бэхжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, хамтын ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор Аймгийн ГХУСАСЗ хууль хяналтын байгууллагуудын нэгдсэн ярилцлага хийлээ. Сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сарын ажлын тайланг нэгтгэн дүгнэлт хийж, хүүхэд, эмэгтэйчүүдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах байнгын ажиллагаатай байртай болгох асуудлыг аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2015 оны зорилтонд тусгалаа.



Архидан согтуурахтай тэмцэх, архи тамхины хуулийг хөдөө орон нутагт сурталчлах зорилгоор цагдаагийн газар, “АА” ассоциацитай хамтран сумдад бүсчилсэн сургалт, мэдээлэл хийж иргэдэд үйлчлэх “Итгэлтэй утас” 70452525

байнга ажиллуулж сэтгэл зүйн зөвлөгөө өгч байна.

Аймгийн ГХУСАЗСЗ-ийн гишүүд Бөхмөрөн, Өндөрхангай, Тэс сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүн, гэмт хэрэг гаралтын нөхцөл байдалтай танилцах, цаг үеийн ажлын мэдээлэл өгөх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх талаар иргэдтэй уулзаж, цаашид хийх ажлыг тодорхойлон уулзалт ярилцлагаар гарсан санал дүгнэлтэнд үндэслэн 19 суманд зөвлөмж хүргүүлж, байгаль орчныг хамгаалах, хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэгтэй тэмцэхээр холбогдох байгууллагуудын ажлыг эрчимжүүлэхэд хяналт тавин ажиллахыг мэдэгдлээ.

Аймгийн ГХУСАЗСЗ-өөс 2014 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд жигд явуулах, олон нийтэд зориулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулж, мэдээллээр хангах, гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг хурдан хүлээн авч холбогдох арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэн ажиллахад анхаарлаа хандуулахыг зорилт болгон тавьсан. Үүний дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл, сургалт сурталчилгааг үе шаттайгаар аймгийн Прокурор, Цагдаагийн газар хамтран нийт 18 сум, 8 багт, мөн тусгайлсан удирдамжийн дагуу аймгийн ИТХ, ЗДТГ-ын ХЗХ, аймгийн Прокурор, Цагдаагийн газар, Хилийн 0245-р ангийн захирагч албан хаагч нартай хамтран Бөхмөрөн сумын 1,2,3-р багийн иргэд, хилийн I заставтын хугацаат болон гэрээт цэргийн албан хаагчдад хүрч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх хууль эрх зүйн шинэтгэлийн хүрээнд шинэчлэгдсэн хуулиудад тулгуурласан мэдээлэл сурталчилгааг явууллаа.

- Цагаатгалын асуудлаар улсын комиссын мэдээллийн санд бүртгэгдсэн Увс аймагтай

холбоотой 48 нэхэмжлэлийн мөрөөр хаяг тодруулах судалгаа явуулж, 8 иргэний өргөдөл, 3 иргэний гомдол, 17 иргэний хүсэлтийг уламжлан шийдвэрлүүлэх арга хэмжээ авч 54 иргэнийг хүлээн авч уулзан санал хүсэлтийг сонсож, хууль эрх зүйн зөвлөгөө өгч 4 хүнд нөхөх олговрын 4 сая төг олголоо. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх ажлыг 9-р сард аймаг, суманд зохион байгуулж, хэлмэгдсдийн хөшөө, дурсгалд хүндэтгэл үзүүлж, үр хүүхдүүдэд гарын бэлэг гардуулж, сүм хийдэд буяны ном хуруулж,төв суурин газруудад нийтийг хамарсан ёслол хүндэтгэлийн арга хэмжээ, оюутан сурагчдын дунд Хүндэтгэлийн хичээл хийх, зохион биччлэгийн уралдаан зарлах зэрэг ажлуудыг зорион байгуулж, Увс аймаг дахь цагаатгалын ажлын үр дүнг нэгтгэсэн “Цагаатгалын ажил цагаан мөртэй” номыг хэвлүүлж холбогдох байгууллага, иргэд, сумдад хүргүүллээ.

- Шинэ Үндсэн хууль батлагдсаны ойд зориулсан шатрын сум,аймгийн аврага шалгаруулах тэмцээнийг 2 үе шаттайгаар аймгийн шатрын холбоотой хамтран зохион байгуулж эхний 3 байр эзлэгсдийг шагнаж урамшуулан улсын аварга шалгаруулах

тэмцээнд оролцоход нь дэмжлэг үзүүлж, эмэгтэйчүүдийн төрөлд шатарчин Ж.Алтанцэцэг улсад 3-р байранд шалгарлаа.

- Увс аймагт НӨУБ үүсч хөгжсөний 22 жил, МНУХ-ны 20 жилийн ойг тохиолдуулан аймгийн ИТХ-аас хүндэтгэлийн арга хэмжээг явуулж, ойг 7 суманд тусгайлан тэмдэглэх арга хэмжээг зохион байгуулсны дотор Улаангом сумын ИТХ Хүндэтгэлийн хуралдаан хийж, өнгөрсөн 6 удаагийн бүрэн эрхийн хугацаанд аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдон ажиллаж байсан хүмүүст батламж гардуулж, аймгийн болон МНУХ-ны шагналаар 30 гаруй хүнийг шагнаж үе үеийн төлөөлөгчдөд хүндэтгэл үзүүллээ.
- Аймгийн ИТХ-ын Түргэн, Өндөрхангай, Улаангом сумын 4-р багийн тойрогт, Малчин, Сагил сумын ИТХ-ын 2 тойрогт нөхөн сонгууль явагдаж, сумын ИТХ-ын 3 төлөөлөгч намын жагсаалтаас нөхөн сонгогдсоныг тус тус бүрэн эрхийг нь баталгаажуулж, сумын ИТХ-ын 6 төлөөлөгч төрийн албанд шилжиж, нас барсан зэрэг өөрчлөлт орсныг чөлөөллөө.
- Бөхмөрөн сумын Засаг дарга Д.Ядамжав ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасны дагуу чөлөөлж, сумын ИТХ-аас дараагийн Засаг даргад нэр дэвшүүлснийг батламжиллаа. 2014 онд аймаг, сумын ИТХ тараагүй. Аймаг, сумын ИТХ-ын шийдвэрт Засаг дарга хориг тавиагүй байна.

Санал, дүгнэлт: Аймгийн хэмжээнд хурлын шийдвэр, дотоод ажлын төлөвлөгөөний биелэлт, ажлын албаны бичиг хэргийн эмх цэгц, өрөө танхимын тохижилт, техник хэрэгслийн хангамж сайжирч, үйл ажиллагаа нь жигдэрч, хөгжлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд Хурлын хороо, төлөөлөгчид, иргэдийн оролцоо нэмэгдэж, орон нутагт хийгдэж буй хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажилд тавих хяналт сайжирч, айл өрх, иргэн бүрт хүрч ажиллах ажилд зохих ахиц гарч “Оролцоонд тулгуурласан, ил тод нээлттэй байдлыг хангах” стратегийг хэрэгжүүлэхэд ахиц өөрчлөлт гарч байна. Гэвч

1. 2014 онд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс багийн зохион байгуулалтыг боловсронгуй болгох тухай тогтоол гаргасан боловч аймгийн ЗДТГ, Улаангом сумын ИТХ, Засаг дарга нар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй, аймгийн төвийн сумдыг орон нутгийн хотын статустай болгох асуудал хүлээгдэж байгаагаас бүрэн хэрэгжээгүй болно. Иймд багийн өрх, хүн ам, газар нутаг харилцан адилгүй, ачаалал нь жигд бус байгааг жишиг тогтоож тэнцвэржүүлэх, аймгийн төвүүдийн багийн талаар судалгаа хийж зохистой шийдлийг олох

2. Аймаг, сумын ИТХ, ГХУСА-ын үйл ажиллагааны зардал хүрэлцээгүй, багийн ИНХ төсөвгүй, үйл ажиллагааны зардалгүй, багийн ИНХ-ын дарга нарын урамшуулал хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хүрэхгүй байгаа нь аймгийн НӨУБ-ын үйл ажиллагаа анхан шатны нэгждээ доголдох үндэслэл болж шууд ардчилал, НӨУБ-ын хөгжил төлөвшилд нөлөөлж байгааг

3. Хурлын ажлын албаны мэргэжилтнүүдийг үе шаттайгаар сургалтанд хамруулж мэргэшүүлэх, хурлын ажлын албаны бүтэц, орон тоо, чиг үүргийг үндэслэлтэй судлаж тогтоох, сумын ИТХ-ын дарга, багийн ИНХ-ын дарга нарт нас, боловсролын шалгуур тавих, цалин урамшуулыг нэмэгдүүлэх зэрэг асуудлыг холбогдох байгууллагуудад уламжилж, зохих хууль, тогтоол шийдвэрүүдийг гаргуулах

4. Увс аймаг 2013-2014 онд сумдын ИТХ-ын дэргэд 19 иргэний танхимыг 360 сая төгрөгөөр байгуулан тохижуулж техник хэрэгсэлээр хангаж, иргэний танхимын ажилтнуудыг сонгон шалгаруулан томилж, хэлэлцүүлэг, санал асуулга зохион байгуулж, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, уламжлан шийдвэрлүүлдэг болж шууд ардчилалыг хөгжүүлэхэд зохих ахиц дэвшил гарсан билээ. Гэтэл 2014 онд Засгийн газраас аймгийн ИТХ-ын бүтэц орон тоог 2012 оны түвшинд ажиллуулахаар төсвийг нь хянасан учраас аргагүйн эрхэнд иргэний танхимын ажилтнуудыг одоогийн байдлаар орон тооны хувьд нь сумын ЗДТГ-т шилжүүлэх шийдвэр гаргаад байна. Энэ нь цаашид иргэдийн оролцоог хангах, иргэдийн санал хүсэлтийг сонсох, шууд ардчилалыг хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлэх боломжийг багасгаж энэ асуудалд ИТХ-ын оролцоо, хяналтанд сөргөөр нөлөөлж байгааг залруулах

5. Төсвийн тухай хуулинд сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга төсвийн менежер байх, тушаал гаргана гэсэн заалт байдаг. Энэ заалт суманд хэрхэн хэрэгжих, сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын эрх, үүргийн асуудлыг тодруулах, Засгийн газрын тогтоолоор сумын Засаг даргатай хамт сумын ИТХ-ын дарга нарын цалин, урамшууллыг нэгдсэн журмаар тогтоодог байх, бусад төрийн албаны баримт бичгүүдэд тэдний статус, баталгааг нь тусгах зэрэг асуудалд анхаарал тавьж зохих шийдвэр гаргаж журамлаж мөрдүүлэх шаардлагатай байна.

6. Аймгийн ИТХ-ын ажлын алба 2012 онд 7 орон тоотой ажиллаж байсан. 2014 онд аймгийн ОНӨ-ийн албыг ИТХ-ын ажлын албаны бүтцэд нэгтгэснээр бүгд 10 орон тоогоор ажиллахаар төсөв өгсөн. Иймд аймгийн ИТХ-ын үйл ажиллагаа хэвийн явуулах боломжийг хангаж одоо ажиллаж байгаа 14 орон тоогоор цаашид ажиллуулах

7. УИХ-ын төрийн байгуулалтын байнгын хороо, Нутгийн удирдлагын дэд хорооноос бүх шатны ИТХ-уудын 2015 оны төсвийн байдалд хяналт явуулж, өөрчлөн батлаж мөрдүүлэх шаардлагатай байгаа зэрэг асуудлыг анхааралдаа авч шийдвэрлэхийг санал болгож байна.

Товч тайлан бичсэн:

Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга

Б.Оюунбат

Мэргэжилтэн

Д.Энхцэцэг

Танилцсан: Аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд